



2025 оны I улирал

# ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Орхон аймаг

Нэг.Эх хүүхдийн эрүүл мэнд


Төрөлт

Аймгийн хэмжээнд 2025 оны 1-р улирлын байдлаар 485 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 18 төрөлтөөр буюу 3.6 хувиар буурч,төрсөн эхчүүдийн 453 нь буюу 93.4 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс удаа хамрагдсан нь өмнөх оноос 17.5 хувиар өссөн байна. Нийт төрөлтөд амьгүй төрөлт 3 буюу 0.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 тохиолдлоор буюу 0.2 хувиар буурч,гэрийн төрөлт өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна. Орон нутгаас Орхон аймагт ирж амаржиж буй эхчүүдийн 8.2 хувь нь Булган аймаг, 4.3 хувь Сэлэнгэ аймаг, 3.7 хувь нь Улаанбаатар хот, 1.6 хувь нь Архангай 1.0 хувь нь Хөвсгөл аймгууд эзэлж байна.

Орон нутгаас ирж амаржсан эхчүүд бодит тоо

|                   | Булган | Сэлэнгэ | УБ хот | Архангай | Хөвсгөл | Завхан | Увс | Дундговь | Өмнөговь | Төв | Ховд | Дархан-уул | Сүхбаатар | Дорноговь | БҮГД | Нийт төрөлтөд |
|-------------------|--------|---------|--------|----------|---------|--------|-----|----------|----------|-----|------|------------|-----------|-----------|------|---------------|
| 2024 оны 1-улирал | 37     | 24      | 23     | 8        | 14      | 2      | 1   | 2        | 1        | 1   | 1    | 0          | 1         | 1         | 116  | 23.1          |
| 2025 оны 1-улирал | 40     | 21      | 18     | 8        | 5       | 2      | 2   | 1        | 1        | 1   | 1    | 1          | 0         | 0         | 101  | 20.8          |
| Өсөлт бууралт     | +3     | -3      | -5     | 0        | -9      | 0      | +1  | -1       | 0        | 0   | 0    | 0          | 0         | 0         | -15  | -2.3          |

Төрсөн эхчүүд насны ангилал хувиар



Насны хувьд 3.7 хувийг 20 хүртэлх насны төрөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5 тохиолдлоор буюу 1.1 хувиар, 27.6 хувийг 35-аас дээш насны төрөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 9 тохиолдлоор буюу 2.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.Мэс заслын аргаар төрүүлсэн эх нийт 126 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 30 тохиолдлоор буюу 19.2 хувиар буурсан байна.

Төрөлтийн мэдээлэл

|                        |               | Төрсөн эх | Амьд төрсөн нярай | Амьгүй төрсөн нярай |
|------------------------|---------------|-----------|-------------------|---------------------|
| 2024 оны<br>1-р улирал | Орхон аймаг   | 503       | 505               | 4                   |
|                        | Аймгуудын дүн | 6528      | 6544              | 34                  |
|                        | Улсын дүн     | 14147     | 14244             | 79                  |
| 2025 оны<br>2-р улирал | Орхон аймаг   | 485       | 488               | 3                   |
|                        | Аймгуудын дүн | 6234      | 6286              | 23                  |
|                        | Улсын дүн     | 13361     | 13482             | 60                  |

Жирэмсэн,төрөлт,төрсний дараах үеийн хүндрэл

Жирэмсэн,төрөх,төрсний дараах үеийн хүндрэл 538 тохиолдол бүртгэгдэж,1000 амьд төрөлтөд 663 ногдож байна.

Нийт хүндрэлд:

- Жирэмсэн үеийн хүндрэл 56.3 хувь
- Төрөх үеийн хүндрэл 43.3 хувь
- Төрсний дараах үеийн хүндрэл 0.2 хувь
- Жирэмсэн,төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл 0.2 хувийг тус тус эзэлж байна.

Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс манас таталтын урьтал 17.4 хувь, төрөх үеийн хүндрэлээс төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулралт 49.5 хувь, төрсний дараах үеийн хүндрэлээс төрсний дараах үеийн цус алдалт 100 хувьтай тэргүүлж байна.Төрөлхийн тэмбүүгийн 2 тохиолдол нь Мэндцэцэн ӨЭМТ-1, Жаргалант СЭМТ-1 тус тус бүртгэгдсэн. Жирэмсэн эмэгтэйчүүдэд БЗДХ болон төрөлхийн тэмбүүгийн тохиолдол нэмэгдэж байгаа нь жирэмсэн эмэгтэйн тэмбүү өвчнийг эрт оношлох, тусламж үйлчилгээний чанар,жирэмсний хяналтыг сайжруулах хэрэгтэйг харуулж байна.

Хүүхдийн эрүүл мэнд

2025 оны 1 улирлын байдлаар аймгийн хэмжээнд 488 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 17 хүүхдээр буюу 3.4 хувиар буурчээ. Төрөлтийн түвшин 1000 хүн амд 4.6 өмнөх оны мөн үеэс 0.1 промиллоор буурсан. Амьд төрсөн хүүхдийн 252 буюу 51.6 хувь нь хүү, 236 буюу 48.4 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 107 хүү ногдож, амьд төрсөн 488 хүүхдээс 12 нярай буюу 2.5 хувь нь 2500 гр-аас доош жинтэй төрж, 4 тохиолдол буюу 0.8 хувь нь төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн.

Амьд төрсөн хүүхэд,эхийн тээлтийн хугацаа,хувиар

| Он                  | Эхийн тээлтийн хугацаа эзлэх хувь |                      |                      |                      |                        | Төрөлхийн гажигтай төрсөн | 2500 гр-аас доош жинтэй төрсөн |
|---------------------|-----------------------------------|----------------------|----------------------|----------------------|------------------------|---------------------------|--------------------------------|
|                     | 22-28 долоо хоногтой              | 29-32 долоо хоногтой | 33-36 долоо хоногтой | 37-41 долоо хоногтой | 42 долоо хоногоос дээш |                           |                                |
| 2024 оны 1-р улирал | 0.6                               | 1.0                  | 5.0                  | 93.7                 | 0.0                    | 0.6                       | 5.5                            |
| 2025 оны 1-р улирал | 0.4                               | 0.8                  | 3.1                  | 95.7                 | 0.0                    | 0.8                       | 2.5                            |

Тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад давхардсан тоогоор 23464 хүүхэд хамрагдсанаас 0.14 хувь нь туранхай, 0.16 хувь нь тураалтай, 0.32 хувь нь өсөлтийн хоцрогдолтой, Д амин дэм уусан 21734 хүүхэд байна.

Эхийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2024, 2025 оны 1-р улирлын байдлаар эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.

Нялхсын эндэгдэл

2025 оны 1-р улирлын байдлаар нялхсын эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдэж,1000 амьд төрөлтөд 10.2 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор буюу 4.3 промиллоор нэмэгдэж,нялхсын эндэгдлийн 3 буюу 60.0 хувийг нярайн эндэгдэл эзэлж 1000 амьд төрөлтөд 6.1 байна. Нярайн эндэгдлийн нийт 3 тохиолдлын 2 буюу 66.7 хувь нь эрт үеийн эндэгдэл,1 буюу 33.3 хувийг 7-28 хоногтой нярайн эндэгдэл тус тус эзэлж байна.Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үеийн эмгэг 40.0 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг,төрөлхийн тэмбүү,осол гэмтлийн шалтгаант нас баралт тус тус 20.0 хувийг эзэлж байна.

Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд



1000 амьд төрөлтөд

|                  | 2024 оны 1-р улирал |                 |                     | 2025 оны 1-р улирал |                 |                     |
|------------------|---------------------|-----------------|---------------------|---------------------|-----------------|---------------------|
|                  | Нялхасын эндэгдэл   | Нярайн эндэгдэл | Перинаталь эндэгдэл | Нялхасын эндэгдэл   | Нярайн эндэгдэл | Перинаталь эндэгдэл |
| Орхон аймаг      | 5.9                 | 5.9             | 13.8                | 10.2                | 6.1             | 10.2                |
| Аймгуудын дундаж | 10.5                |                 | 8.4                 | 12.7                |                 | 9.8                 |
| Улсын дундаж     | 12.0                | 6.7             | 10.0                | 14.2                | 10.0            | 11.8                |


Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдэж,1000 амьд төрөлтөд 10.2 ногдож байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 2 тохиолдлоор буюу 4.3 промиллоор өссөн байна.

Хоёр.Эмнэлгийн тусламж үйлчилгээ


Амбулаторийн тусламж үйлчилгээ

Аймгийн хэмжээнд 2025 оны 1-р улирлын байдлаар нийт 204217 эмчийн үзлэг хийгдсэнээс 34.3 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 44.0 хувийг өвчний учир амбулаторт, 6.8 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 14.5 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Нэг их эмчид ногдох үзлэгийн тоо 431 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өвчний учир амбулаторийн үзлэг 1.6 хувь, гэрийн идэвхтэй хяналт 0.2 хувиар буурч, урьдчилан сэргийлэх үзлэг 1.8 хувь, идэвхитэй хяналт 0.1 хувиар тус тус өссөн байна. Эмчийн үзлэгийг эмнэлгийн төрлөөр харуулбал: 47.0 хувийг өрхийн эмчийн, 26.5 хувийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн, 14.7 хувийг хувийн хэвшлийн клиникийн, 5.3 хувийг Эрдэнэт сувиллын, 4.9 хувийг Эрдэнэт медикал төрөлжсөн эмнэлгийн, 1.5 хувийг сумын эмчийн үзлэг эзэлж байна.

|                     | ЭМБ-ууд     | Нийт үзлэг | Үүнээс                    |                     |                        |                 |                 |                   |
|---------------------|-------------|------------|---------------------------|---------------------|------------------------|-----------------|-----------------|-------------------|
|                     |             |            | Урьдчилан сэргийлэх үзлэг | Нийт үзлэгт эзлэх % | Өвчний учир амбулаторт | Идэвхтэй хяналт | Гэрийн идэвхтэй | Гэрийн дуудлагаар |
| 2024 оны 1-р улирал | СЭМТ        | 3032       | 1533                      | 50.6                | 273                    | 189             | 796             | 241               |
|                     | БОЭТ        | 51896      | 6876                      | 13.2                | 40613                  | 4401            | 2               | 4                 |
|                     | ӨЭМТ        | 90531      | 48887                     | 54.0                | 5062                   | 8033            | 27946           | 603               |
|                     | ХХЭМБ       | 26537      | 1617                      | 6.1                 | 24620                  | 284             | 13              | 3                 |
|                     | ЭТ сувилал  | 11922      | 2479                      | 20.8                | 9096                   | 308             | 38              | 1                 |
|                     | ЭТ медикал  | 12385      | 2496                      | 20.2                | 9889                   |                 |                 |                   |
|                     | Аймгийн дүн | 196303     | 63888                     | 32.5                | 89553                  | 13215           | 28795           | 852               |
| 2025 оны 1-р улирал | СЭМТ        | 3178       | 862                       | 27.1                | 324                    | 408             | 730             | 197               |
|                     | БОЭТ        | 54163      | 9441                      | 17.4                | 39703                  | 5017            |                 | 2                 |
|                     | ӨЭМТ        | 96015      | 52822                     | 55.0                | 5809                   | 8001            | 28826           | 557               |
|                     | ХХЭМБ       | 29999      | 3260                      | 10.9                | 27073                  | 323             |                 |                   |
|                     | ЭТ сувилал  | 10801      | 2134                      | 19.8                | 8328                   | 323             | 14              | 2                 |
|                     | ЭТ медикал  | 10061      | 1524                      | 15.1                | 8537                   |                 |                 |                   |
|                     | Аймгийн дүн | 204217     | 70043                     | 34.2                | 89774                  | 14072           | 29570           | 758               |



Нэг иргэн дунджаар 1.9 удаа эрүүл мэндийн байгууллагад хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан нь өмнөх оны түвшинд байна.



Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Аймгийн хэмжээнд артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 15052 (29.9%) хүн хамрагдсан бөгөөд 39.3 хувь нь эрэгтэй, 60.7 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн 0.7 хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 13704 (27.1%) хүн хамрагдсанаас 38.7 хувь нь эрэгтэй, 61.3 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.4 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 404 (23.1%) хүн хамрагдсан.


|                     |           | АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ ЭРТ ИЛРҮҮЛЭГ |                                 |                    | ЧИХРИЙН ШИЖИН ХАМ ШИНЖ -2 ЭРТ ИЛРҮҮЛЭГ |                                 |                   |
|---------------------|-----------|----------------------------------|---------------------------------|--------------------|----------------------------------------|---------------------------------|-------------------|
|                     |           | Хамрагдсан хүний тоо             | Оношлогдсон артерийн гипертензи | Хамрагд алтын хувь | Хамрагдсан хүний тоо                   | Оношлогдсон артерийн гипертензи | Хамрагдалтын хувь |
| 2024 оны 1-р улирал | Орхон     | 14353                            | 56                              | 28.3               | 9884                                   | 31                              | 19.5              |
|                     | Улсын дүн | 340923                           |                                 | 16.0               | 284512                                 |                                 | 21.2              |
| 2025 оны 1-р улирал | Орхон     | 15052                            | 110                             | 29.9               | 13704                                  | 51                              | 27.1              |
|                     | Улсын дүн | 367544                           |                                 | 17.2               | 302524                                 |                                 | 22.5              |

Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 1507 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 30.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар нэмэгдэж,пап шинжилгээнд нийт 344 сорьц хүлээн авсан. Хөхний эрт илрүүлэг үзлэгт 5816 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 28.2 хувийг эзэлж,өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар нэмэгдсэн байна.

Жирэмсний хяналт

Жирэмсний хяналтад шинээр 411 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдан эхний 3 сартайд 405 буюу 98.5 хувь нь хяналтад орж, өмнөх оны мөн үеэс эрт үеийн хяналт 1.1 хувиар буурсан. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.5 хувь цусны шинжилгээнд хамрагдсанаас 18 буюу 4.4 хувь нь цус багадаалттай байна. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлтэд трихомониаз 13 буюу 3.2 хувь, тэмбүү 3 буюу 0.7 хувь тус тус эерэг гарсан байна.

Эрт үеийн жирэмсний хяналт



Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлтэд трихомониаз 13 буюу 3.2 хувь, тэмбүү 3 буюу 0.7 хувь тус тус эерэг гарсан байна.

БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлт

|                     |               | Трихомониаз эерэг | Заг хүйтэн эерэг | Тэмбүү эерэг |
|---------------------|---------------|-------------------|------------------|--------------|
| 2024 оны 1-р улирал | Орхон аймаг   | 12                | 1                | 3            |
|                     | Аймгуудын дүн | 68                | 10               | 72           |
|                     | Улсын дүн     | 172               | 15               | 263          |
| 2025 оны 1-р улирал | Орхон аймаг   | 13                | 0                | 3            |
|                     | Аймгуудын дүн | 55                | 2                | 57           |
|                     | Улсын дүн     | 147               | 10               | 170          |

Үр хөндөлт

Аймгийн хэмжээнд 2025 оны 1-р улирлын байдлаар нийт 89 эмэгтэйчүүд үр хөндөх мэс ажилбарыг хийлгэсэн ба өмнөх оны мөн үеэс 26 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 20 хүртэлх насны үр хөндөлтийн тохиолдол 4 (4.5%), хожуу үр хөндөлт бүртгэгдээгүй.

Үр хөндөлтийн түвшин

|               | Үр хөндөлтийн тоо      |                        | Үр хөндөлтийн харьцаа<br>(1000 амьд төрөлтөд) |                        |
|---------------|------------------------|------------------------|-----------------------------------------------|------------------------|
|               | 2024 оны<br>1-р улирал | 2025 оны<br>1-р улирал | 2024 оны<br>1-р улирал                        | 2025 оны<br>1-р улирал |
| Орхон аймаг   | 63                     | 89                     | 124.8                                         | 182.4                  |
| Аймгуудын дүн | 821                    | 804                    | 125.5                                         | 127.9                  |
| Улсын дүн     | 3121                   | 3005                   | 219.1                                         | 222.9                  |

Охидын жирэмслэлт,төрөлт,үр хөндөлт

|                     | Өсвөр насны охидын           |                             |                         |                             |
|---------------------|------------------------------|-----------------------------|-------------------------|-----------------------------|
|                     | жирэмслэлтийн<br>коэффициент | жирэмслэлтийн<br>эзлэх хувь | төрөлтийн эзлэх<br>хувь | үр хөндөлтийн<br>эзлэх хувь |
| 2024 оны 1-р улирал | 1.3                          | 0.4                         | 2.6                     | 3.2                         |
| 2025 оны 1-р улирал | 1.8                          | 0.6                         | 3.7                     | 4.5                         |
| Өсөлт бууралт       | +0.5                         | +0.2                        | +1.1                    | +1.3                        |

Түргэн тусламжийн дуудлага

3910 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 1.3 хувийг алсын, 6.8 хувийг осол, гэмтлийн дуудлага эзэлж байна.

|                        | Түргэн тусламжийн дуудлага |                   |                              | Алсын<br>дуудлагын<br>эзлэх хувь | Осол,гэмтлийн<br>дуудлагын<br>эзлэх хувь |
|------------------------|----------------------------|-------------------|------------------------------|----------------------------------|------------------------------------------|
|                        | Нийт                       | Алсын<br>дуудлага | Осол<br>гэмтлийн<br>дуудлага |                                  |                                          |
| 2024 оны<br>1-р улирал | 3942                       | 79                | 590                          | 2.0                              | 15.0                                     |
| 2025 оны<br>1-р улирал | 3910                       | 49                | 264                          | 1.3                              | 6.8                                      |
| Үзүүлэлт               | -32                        | -30               | -326                         | -0.7                             | -8.2                                     |

Хэвтэн эмчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ

2024 онд тайлан ирүүлсэн 161 эрүүл мэндийн байгууллагаас хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бүсийн оношилгоо эмчилгээний төв 1, өрхийн эрүүл мэндийн төв 8, сумын эрүүл мэндийн төв 1, ортой хувийн клиник 12, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 1, хувийн клиник 52 байна. Аймгийн хэмжээнд 9618 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 63227 ор хоног ашиглаж, ор ашиглалтын хувь 81.3, дундаж ор хоног 6.6 байна.

**Эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд**

|                    | Орны тоо   | Хэвтсэн өвчтөн | Эмчлэгдэж гарсан өвчтөн | Ор хоног     | Эмнэлгийн нас баралт | Хоног болоогүй нас баралт | Хоног болоогүй нас баралтын хувь | Үүнээс                       |                                     | Орны фонд ашиглалт | Фонд ашиглалтын хувь | Дундаж ор хоног | Орны эргэлт |
|--------------------|------------|----------------|-------------------------|--------------|----------------------|---------------------------|----------------------------------|------------------------------|-------------------------------------|--------------------|----------------------|-----------------|-------------|
|                    |            |                |                         |              |                      |                           |                                  | 8-24 цагийн дотор нас баралт | 8-24 цагийн дотор нас баралтын хувь |                    |                      |                 |             |
| БОЭТ               | 433        | 4459           | 4423                    | 28933        | 35                   | 18                        | 51.4                             | 9                            | 50.0                                | 66.8               | 81.0                 | 6.5             | 10.2        |
| СЭМТ               | 12         | 112            | 105                     | 735          |                      |                           |                                  |                              |                                     | 61.3               | 74.3                 | 7.0             | 8.8         |
| ЭТ медицина        | 38         | 408            | 426                     | 1797         |                      |                           |                                  |                              |                                     | 47.3               | 57.3                 | 4.2             | 11.2        |
| ХХЭМБ              | 459        | 4864           | 4664                    | 31762        |                      |                           |                                  |                              |                                     | 69.2               | 83.9                 | 6.8             | 10.2        |
| <b>Аймгийн дүн</b> | <b>942</b> | <b>9843</b>    | <b>9618</b>             | <b>63227</b> | <b>35</b>            | <b>18</b>                 | <b>51.4</b>                      | <b>9</b>                     | <b>50.0</b>                         | <b>67.1</b>        | <b>81.3</b>          | <b>6.6</b>      | <b>10.2</b> |

2025 оны 1-р улирлын байдлаар 10 000 хүн амд дунджаар 89.5 хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ор ногдож байгаа нь өмнөх оны дунджаас 0.1-ээр нэмэгдсэн байна.


**Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10 000 хүн амд**

2025 оны 1-р улирлын байдлаар

| №  | ӨОУА-10 нэршил                                           | Тохиолдлын тоо | 10 000 хүн амд | Нийт тохиолдлын хувь |
|----|----------------------------------------------------------|----------------|----------------|----------------------|
| 1  | Зүрх-судасны тогтолцооны өвчин                           | 1645           | 156.3          | 17.1                 |
| 2  | Амьсгалын тогтолцооны өвчин                              | 1512           | 143.6          | 15.7                 |
| 3  | Хоол боловсруулах тогтолцооны өвчин                      | 1012           | 96.1           | 10.5                 |
| 4  | Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин            | 643            | 61.1           | 6.7                  |
| 5  | Шээс бэлгийн тогтолцооны өвчин                           | 442            | 42.0           | 4.6                  |
| 6  | Мэдрэлийн тогтолцооны өвчин                              | 368            | 35.0           | 3.8                  |
| 7  | Сэтгэцийн ба аягийн эмгэг                                | 332            | 31.5           | 3.5                  |
| 8  | Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 291            | 27.6           | 3.0                  |
| 9  | Жирэмслэн, төрөлт ба төрсний дараах үе                   | 290            | 27.5           | 3.0                  |
| 10 | Хавдар                                                   | 239            | 22.7           | 2.5                  |

Халдварт бус өвчлөл

Аймгийн хэмжээнд 2025 оны 1-р улиралд 10 000 хүн амд ногдох амбулаторийн өвчлөл (18510)-ийн түвшин 1758.4 болж,өмнөх оноос 194.5-аар буурсан байна.



Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10 000 хүн амд

2025 оны 1-р улирлын байдлаар

| №  | ӨОУА-10 нэршил                                           | Тохиолдлын тоо | 10 000 хүн амд | Нийт тохиолдлын хувь |
|----|----------------------------------------------------------|----------------|----------------|----------------------|
| 1  | Амьсгалын тогтолцооны өвчин                              | 4819           | 457.8          | 26.0                 |
| 2  | Хоол боловсруулах тогтолцооны өвчин                      | 3582           | 340.3          | 19.4                 |
| 3  | Шээс бэлгийн тогтолцооны өвчин                           | 2757           | 261.9          | 14.9                 |
| 4  | Зүрх-судасны тогтолцооны өвчин                           | 1997           | 189.7          | 10.8                 |
| 5  | Арьс ба халимны өвчин                                    | 1157           | 109.9          | 6.3                  |
| 6  | Нүд ба түүний дайврын өвчнүүд                            | 1153           | 109.5          | 6.2                  |
| 7  | Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин            | 935            | 88.8           | 5.1                  |
| 8  | Мэдрэлийн тогтолцооны өвчин                              | 695            | 66.0           | 3.8                  |
| 9  | Хавдар                                                   | 590            | 56.0           | 3.2                  |
| 10 | Чих ба хөхөнцрийн өвчин                                  | 292            | 27.7           | 1.6                  |
| 11 | Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 224            | 21.3           | 1.2                  |

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг байршлаар нь үзэхэд: 10 000 хүн амд ногдох амьсгалын тогтолцооны өвчин Зэст багт 2630.4 бүртгэгдэж, амьсгалын тогтолцооны өвчлөлд:

- Цочмог бронхит 1654 буюу 34.3%
- Амьсгалын дээд замын халдвар 864 буюу 17.9%
- Уушгины архаг бөглөрөлт өвчин 622 буюу 12.9%
- Уушгины хатгаа 531 буюу 11.0%
- Томуу,томуу төст 343 буюу 7.1%

Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлд:

- Амны хөндий,шүлсний булчирхай ба эрүүний өвчин 1473 буюу 41.1%
- Цөсний хүүдий,цөсний зам ба нойр булчирхайн өвчин 752 буюу 21.0%
- Улаан хоолой,ходоод,дээд гэдэсний өвчин 600 буюу 16.8%
- Элэгний өвчин 329 буюу 9.2%
- Гэдэсний бусад өвчин 184 буюу 5.1%


Шээс бэлгийн тогтолцооны өвчинд:

- Шээс ялгаруулах тогтолцооны бусад эмгэг 786 буюу 28.5%
- Эмэгтэйн аарцгийн эрхтний үрэвсэл 650 буюу 23.6%
- Бөөрний сувганцрын өвчнүүд 538 буюу 19.5%
- Эр бэлэг эрхтний үрэвсэлт өвчин 279 буюу 10.1%
- Эм бэлэг эрхтний үрэвсэлт өвчин 240 буюу 8.7% тус тус эзэлж байна.

### Хорт хавдрын тэргүүлэх шалтгаан


2025 оны 1-р улирлын байдлаар 107 хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдсоны 43 (40.2%) эрэгтэй, 64 (59.8%) эмэгтэй.Элэгний хорт хавдраар 28 тохиолдол шинээр оношлогдсоны 42.9 хувь эрэгтэй, 57.1 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь нийт хорт хавдрын 26.2 хувийг эзэлж байна.

**Хорт хавдрын өвчлөлийн бүтэц**



Гурав.Хүн амын нас баралт

2025 оны 1-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд нас баралтын 112 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 37 тохиолдлоор буурч нийт нас баралтын 31.3 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 18 тохиолдол буюу 51.4 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж, эмнэлэгт хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор өссөн байна.



Нас баралтын түвшин 1000 хүн амд 1.1 байна. Нас баралтын 4.5 хувийг нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эзэлж, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 12 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 10.7 хувийг эзэлж өнгөрсөн оны мөн үеэс 1 тохиолдлоор өссөн бөгөөд 10 000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 1.1 байна.

Осол гэмтлийн нас баралтын шалтгаан:

|                     | Бүгд | Амиа хорлолт | Бусдад хорлогдсон | Үйлдвэрийн осол | Зам тээврийн осол | Бусад осол |
|---------------------|------|--------------|-------------------|-----------------|-------------------|------------|
| 2024 оны 1-р улирал | 11   |              |                   |                 |                   | 11         |
| 2025 оны 1-р улирал | 12   | 1            |                   |                 | 1                 | 10         |

Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд

|                     | Зүрх судасны тогтолцооны өвчин | Хавдар | Гэмтэл хордлого, гадны шалтгаан | Хоол боловсруулах тогтолцооны өвчин | Дотоод шүүрэл,тэжээлийн ба бодисын солилцооны өвчин |
|---------------------|--------------------------------|--------|---------------------------------|-------------------------------------|-----------------------------------------------------|
| 2024 оны 1-р улирал | 6.3                            | 3.6    | 0.01                            | 0.9                                 | 0.5                                                 |
| 2025 оны 1-р улирал | 3.9                            | 2.8    | 1.1                             | 0.9                                 | 0.09                                                |


Нас баралтын нэгдүгээр шалтгаан болох зүрх судасны тогтолцооны өвчин дотор:

| 2024 оны 1- р улиралд 66                                                                                                                                                                                              | 2025 оны 1- р улиралд 41                                                                                                                                                                                            |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <ul style="list-style-type: none"><li>Тархины цус харвалт 13 буюу 19.7%</li><li>Зүрхний ишеми 26 буюу 39.4%</li><li>Зүрхний шигдээс 9 буюу 13.6%</li><li>Бусад зүрх судасны тогтолцооны өвчин 18 буюу 27.3%</li></ul> | <ul style="list-style-type: none"><li>Зүрхний ишеми 8 буюу 19.5%</li><li>Тархины цус харвалт 10 буюу 24.4%</li><li>Зүрхний шигдээс 9 буюу 22.0%</li><li>Бусад зүрх судасны тогтолцооны өвчин 5 буюу 12.2%</li></ul> |

Хорт хавдрын шалтгаант нас баралт

Хавдраас шалтгаалсан нас баралт 2024 оны мөн үеэс 10 тохиолдлоор буурсан хэдий ч нас баралтын 2 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд нас барагчдыг хүйсээр нь үзэхэд 57.1 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүдээс илүү өвчилж,нас барж байна. 2025 оны 1-р улирлын байдлаар хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын 25.0 хувийг эзэлж, нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 3.1, 10 000 эмэгтэй хүн амд 2.2 ногдож, хавдрын төрлийн дийлэнх нь элэг, ходоод, уушгины хорт хавдраас болж нас барж байна.

Элэгний хорт хавдрын нас баралт,10 000 хүн амд,хүйсээр



Элэгний хорт хавдар нь хүн амын нас баралтыг өвчлөлөөр тооцоход эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нас баралтын 1-р шалтгаан болсоор байгаа бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад 3 тохиолдлоор буурсан байна.

Эмгэг судлалын шинжилгээ

Эхний 3 сарын байдлаар эмнэлгийн нас баралтын 35 тохиолдол бүртгэгдсэнээс 48.6 хувьд нь эмгэг судлалын болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийгдсэн байна.

Эмгэг судлалын шинжилгээний үзүүлэлт

|                     | Эдийн шинжилгээ | Эсийн шинжилгээ | Эмнэлэгт бүртгэгдсэн нас баралт | Хийгдсэн задлан шинжилгээ |                | Амьгүй төрөлт | Амьгүй төрөлтөд хийгдсэн задлан шгээ | Задлан шинжилгээ хийгээгүй | Задлан шинжилгээний хувь | Оношийн зөрүү тоо | Оношийн зөрүүний хувь |
|---------------------|-----------------|-----------------|---------------------------------|---------------------------|----------------|---------------|--------------------------------------|----------------------------|--------------------------|-------------------|-----------------------|
|                     |                 |                 |                                 | Эмгэг судлалын            | Шүүх эмнэлгийн |               |                                      |                            |                          |                   |                       |
| 2024 оны 1-р улирал | 504             | 514             | 17                              | 8                         | 1              | 2             | 0                                    | 8                          | 47.4                     | 0                 | 0.0                   |
| 2025 оны 1-р улирал | 664             | 808             | 35                              | 14                        | 3              | 2             | 1                                    | 18                         | 48.6                     | 0                 | 0.0                   |

Дөрөв.Халдварт өвчин

Аймгийн хэмжээнд 214 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 19.4 ногдож, өмнөх оны мөн үеэс 22 тохиолдлоор нэмэгдсэн байна. 2025 оны эхний 3 сарын байдлаар халдварт өвчний бүтцийг харахад нийт халдварт өвчний 51.4 хувийг амьсгалын замын халдвар эзэлж байгаагийн (71.1 нь салхинцэцэг, 20.2 хувийг сүрьеэ, 6.1 хувийг гахай хавдар, 2.6 хувийг гар хөл амны өвчин) 24.8 хувийг бэлгийн замаар дамжих халдвар, 19.6 хувийг мөөгөнцөр, 0.9 хувийг гэдэсний халдвар, 0.5 хувийг цусаар дамжих халдвар тус тус эзэлж байна.Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 43.6 хувийг тэмбүү, 40.0 хувийг трихомониаз, 16.4 хувийг заг хүйтэн тус тус эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тэмбүүгийн өвчлөл 8 тохиолдол буюу 10 000 хүн амд 2.3 промиллоор нэмэгдэж, төрөлхийн тэмбүү 2 бүртгэгдсэн байна.

Нийт халдварт өвчин 10 000 хүн амд

|             |                     | 2024 оны 1-р улирал | 2025 оны 1-р улирал |
|-------------|---------------------|---------------------|---------------------|
| Орхон аймаг | Нийт халдварт өвчин | 192                 | 214                 |
|             | 10 000 хүн амд      | 17.4                | 19.4                |
| Улсын дүн   | Нийт халдварт өвчин | 8468                | 8600                |
|             | 10 000 хүн амд      | 24.2                | 24.5                |

Халдварт өвчний тохиолдол, нас баралт, төрлөөр

1-р улирлын байдлаар

| №                   | Халдварт өвчин төрөл                 | Өвчлөл |      |               | Нас баралт |      |               |
|---------------------|--------------------------------------|--------|------|---------------|------------|------|---------------|
|                     |                                      | 2024   | 2025 | Өсөлт бууралт | 2024       | 2025 | Өсөлт бууралт |
| 1                   | Амьсгалын замын халдварт өвчин       | 72     | 114  | +42           |            | 1    | +1            |
| 2                   | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин | 51     | 55   | +4            |            | 1    | +1            |
| 3                   | Гэдэсний халдварт өвчин              | 1      | 2    | +1            |            |      |               |
| 4                   | Зоонозын халдварт өвчин              |        |      |               |            |      |               |
| 5                   | Цусаар дамжих халдварт өвчин         | 3      | 1    | -2            |            |      |               |
| 6                   | Бусад халдварт өвчин                 | 65     | 42   | -23           |            |      |               |
| Нийт халдварт өвчин |                                      | 192    | 214  | +22           | 0          | 2    | +2            |